



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/350

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.17, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам батлах тухай” 08 дугаар тогтоолыг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр Самбалхүндэв (далан давхар)-ийн хаалттай оршуулгын газрын дахин төлөвлөлтийн ажлын бэлтгэл хангах хүрээнд хийсэн зөвлөх үйлчилгээний гэрээт ажлыг хүлээн авч, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүлээлгэн өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Дүүргийн менежер

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын
Төлөвлөлт, гүйцэтгэлийн
удирдлагын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын
Архивын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй
харилцах тасгийн дарга

Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн
байгуулалтыг дэмжих төв
ОНӨААТҮГ-ын захирал

Нарийн бичгийн дарга:

Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга

2.Гэрээт ажлыг хүлээн авч, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд хүлээлгэн өгч үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Л.Цэеэрэгзэн)-т үүрэг болгосугай.

1525011048

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч
(З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ